

МОНГОЛ АМЕРИКИЙН ЭРДЭМТДИЙН ХАРИЛЦААНЫ ТОЙМ

*Д.Эрдэнэ-Отгон**

Монгол, Америкийн эрдэмтдийн эрдэм судлалын хамтын ажиллагаа ихээхэн өргөжиж буй өнөө үед энэ сэдвээр судалгаа үргэлжлүүлэн хийх нь сонирхолтой бөгөөд туйлын ач холбогдолтой юм. Ер нь эрдэмтдийн санаа бодол бол аливаа улс орны гадаад бодлогод их үүрэг гүйцэтгэдэг. Тэр ч байтугай улс орноо дээшлэн хөгжүүлэхэд эрдэмтдийн үүрэг роль нэг их байдаг билээ. Ийм бодит түүхэн амьдрал Америкад ч, Монголд ч байсан, байсаар байна.

Монгол, Америкийн эрдэмтдийн хамтын ажиллагаа яаж эхэлсэн, ямар бартаатай замыг туулсан, Монголыг НҮБ-д элсэхэд, Монгол-АНУ-н хооронд дипломат харилцаа тогтооход Америкийн эрдэмтдээс хэрхэн зүтгэл гаргаж өөрийн гэсэн хувь нэмрээ оруулсан зэргийг нарийвчлан судалбал их сонирхолтой юм. Дээрхи үеийг Америк-Монголын эрдэмтдийн хамтын ажиллагаа гэж нэрлэбэл бүр ч үнэнд ойртох мэт. Сүүлийн үед манай монголын эрдэмтэд Монгол-Америкийн харилцааг нилээд жинтэй судалж эхэлсэн байна. Тухайлбал Академич Н.Ишжамц¹, Ч.Далай², доктор Ц.Батбаяр³, А.Дамдинсүрэн⁴, Ц.Пунцагноров⁵, Г.Төмөрчулуун⁶, Ж.Бор⁷, С.Ишдорж⁸, М.Хурметхан⁹, С.Жамбалдорж¹⁰, Д.Цолмон¹¹ нарын олон эрдэмтний нэрийг дурьдаж болно.

Монгол улсын нутгаар Америкийн эрдэмтэд анх 1922 оны эхээр орж иржээ. Тэр нь хэдийгээр дан ганц Америкийн талын эрдэм шинжилгээний хээрийн хайгуулын ажил байсан боловч Монголын нутаг дэвсгэрийн удмыг, арвин баялаг түүх дурсгал ихтэйг, хүн ард нь сайхан сэтгэлтэй болохыг олж мэдэж цаашлан Америкад мэдээлсэн ажээ.

Америкийн Р.Ч.Эндрюс тэргүүтэй Төв Азийн шинжилгээний анги юм. Тэр шинжилгээний анги 1922-1930 оны хооронд Монголд таван удаа орж ирж Өмнөговь, Дундговь аймгийн нутгаар шинжилгээ судалгааны ажил хийжээ.

Энэ тухай академич Н.Ишжамц бичсэн нь: “Америкийн тэрхүү шинжилгээний ангийн нээлт ололт нь монгол улсын нэр хүндийг олон улсын тавцан дээр өргөн дуурсгаж, дэлхий дахины анхаарлыг Монгол

*Д.Эрдэнэ-Отгон - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

орны зүг XIII, XIV зууны үеэс хойш дахин нэг удаа шууруулан хандуулсан байна”¹² гэжээ. Р.Ч.Эндрюсийн шинжилгээний анги буцаж очоод олон жил шургуу хөдөлмөрлөж байж агуу том бүтээл туурвисан байна.

Эзэн Чингисийн төрж өссөн, улс байгуулсан унаган гал голомтыг сахиж байсан ар монголчууд 1921 онд санаа нэгдэн хувьсгал хийж Монгол улсынхаа тусгаар тогтнолыг сэргээсэн юм. БНМАУ-ын үеийн Монгол, Америкийн харилцаа хэд хэдэн үе шаттайгаар явж ирсэн юм. Хоёр улсын харилцааг ойлголцуулан урагшлуулахад мөн л эрдэмтдийн зохиол бүтээл, санал шүүмж, мэдээ танилцуулга их үүрэг гүйцэтгэжээ. Америкийн эрдэмтэдээс анх Монголд ирж зохиол бүтээл бичсэн нь Р.А.Рупен юм. Тэрээр 1958 онд монголч эрдэмтдийн анхдугаар их хуралд хүрэлцэн ирж оролцоод богино хугацаанд ч гэсэн монголын төв хэсгийн байрлалтай цухас танилцаад булжээ. Р.А.Рупен 1964 онд “Хорьдугаар зууны монголчууд”¹³ гэсэн зохиол бичжээ. Эерэг сөрөгийн дэнсэн дээр бичсэн энэ зохиол дэлхий дахинд их тархсан. Монголын засгийн газар нэг хэсэгтээ Р.А.Рупенд таагүй хандаж байсан нь хоёр системийн сөргөлдөөнтэй холбоотой байлаа. Гэвч Р.А.Рупен бол БНМАУ-ын байдлыг нилээд бодитойгоор бичсэн анхны эрдэмтэн юм. Түүний тэрхүү зохиол 1990 онд монголоор орчуулагдан Улаабаатарт хэвлэгдэв.

Монгол-Америкийн эрдэмтдийн хамтын ажиллагааг эхлэн хөгжүүлэхэд ихээхэн зүтгэл гаргасан хоёр эрдэмтний тухай товч өгүүлье гэж бодлоо. Энэ нь О.Латтимор, Роберт А.Скалапино нар юм. Ялангуяа О.Латтимор Монгол Америкийн харилцааг итгэлцүүлэн хөгжүүлэхэд, Монгол улсын байдлыг Америк болон өрнөдийн орнуудад ойлгуулахад, Монгол Америкийн хамтын ажиллагааг идэвхжүүлэхэд нэн чухал үүрэг гүйцэтгэжээ. О.Латтимор бол монголчуудын талаар олон зохиол бүтээл бичсэн агуу том эрдэмтэн юм. Түүний бичсэн олон боть зохиолын зарим хуудсыг эргүүлэн сөхөж үзэхэд монголчуудын талаар их судалгаа хийсэн болох нь илт байна. Эхэн үедээ Өвөрмонгол, тухайлбал Хятад дахь монголчуудын талаар голчлон судалгаа хийж түүнд БНМАУ-ын талаар мэдээ сэлт тун ховор байснаас бодит үнэнг хазайлгаж бичиж байсан тал ч харагдана. Үүнийгээ өөрөө ч хүлээн зөвшөөрсөн байна. О.Латтимор 1961 онд эхнэрийнхээ хамт Монголд ирж монгол нутгаар аялан явжээ. Тэр жил бол Монгол Ардын хувьсгал ялсны 40 жилийн ой, Монголын шинжлэх ухааны Академи байгуулагдсан анхны жил байжээ. О.Латтимор Өвөрхангай, Архангай аймгаар сар шахам аялж, Дуурийн театрт Ардын хувьсгалын 40 жилийн ойд зориулсан баярын

концерт үзжээ. Үзээд сэтгэл нь маш их хөдөлсөн байдаг. Мөн ШУА-ийн ерөнхийлөгч Б.Ширэндэвтэй хоёр гурван удаа уулзаж ШУА байгуулагдсан тухай, монголын эрдэмтдийн талаар их зүйлийг сонсож мэджээ. Тэр тухайгаа О.Латтимор “Монгол улс жинхэнэ улс шиг улс болжээ. Би арай ийм байна гэж бодсонгүй. Ямар олон жүжигчин, яасан сайхан концерт тоглов. Театр дүүрэн хүн үзэж байна. Олон сайн эрдэмтэнг эгнээндээ багтаасан ШУА-тай болжээ. Танай ШУА чинь улсын тулах хөл, эрдэмтэд нь хөтлөх тархи болно шүү дээ”¹⁴ гэжээ. О.Латтимор Монгол улсад зочилж буцаад 1962 онд “Нүүдэлчид ба хувьсгалчид”¹⁵ гэдэг зохиол бичиж нийтлүүлжээ. Энэ зохиол нь манай улсын үнэн бодит байдлыг эрдэмтэн хүний нэрээр олж харсан сайн бүтээл болсон ажээ. О.Латтимор тэрхүү номдоо тэмдэглэсэн нь: “АНУ-аас Монголтой дипломат харилцаа тогтоох явдал нь “мэдээ цуглуулах газар” буюу цаашилбал Зөвлөлт улс ба Хятадын хооронд ан цав гаргах тохиромжтой газартай болно гэсэн үг биш шүү”¹⁶ гэжээ. Ер нь О.Латтимор монголын бодит үнэнийг маш сайн ухаарч мэдэрсэн эрдэмтэн байжээ. Ялангуяа монголын эрдэмтдийг Америкийн эрдэмтэдтэй холбож өгөх талаар их зүтгэл гаргажээ. Ганц жишээ дурьдахад 1975 оны намар академич Ш.Нацагдорж, Ш.Бира, Н.Ишжамц нар дэлхийн түүхчдийн их хуралд оролцохоор АНУ-д очиж Америкийн эрдэмтэдтэй уулзаж холбоо тогтооход О.Латтимор зуучлан их үүрэг гүйцэтгэжээ. О.Латтимор БНМАУ-ыг НҮБ-ын гишүүн болгоход /1961-10-27/, Монгол Америкийн хооронд дипломат харилцаа тогтооход /1987-1-27/ өөрийн гэсэн дуу хоолой гаргаж хувь нэмрээ оруулсан эрдэмтэн юм.

О.Латтимор Монголд үнэхээрийн элэгтэй монгол судлалын томоохон эрдэмтэн төдийгүй улс төрийн том зүтгэлтэн, гадаад бодлогын нэртэй ажилтан байсан байна. Энэ нь түүний монголыг судалсан 40 гаруй жилийн нугачаатай хөдөлмөр зүтгэлээс тодорхой харагдах ажээ.

О.Латтимор иймэрхүү зүйлүүдийг ярьж байсныг би миний аав Ч.Далайн тэмдэглэлээс олж уншсан билээ. Үүнд: “Монгол улс хөл дээрээ зогсжээ. Бие даасан төр улс болж өөрийн гэсэн их сургуультай, академитай, соёл урлагтай болжээ... Та нар оросыг дагадаг нь тун зөв болжээ. Орос хүний ачийг битгий мартаарай. Оросууд та нарыг сүрхий дэмжжээ. Цаашид оросууд та нарт туслана байх... Танай улсын тусгаар тогнолд Т.Рузвельт их үүрэг гүйцэтгэсэн... Монгол улс үнэхээр бие даасан тусгаар улс болсон бол түүнийг хөгжүүлэх амархан гэж Рузвельт хэлсэн”¹⁷ гэх мэтээр ярьжээ.

О.Латтиморын дараагаар Америкийн эрдэмтэд дотроос Монголын эрдэмтэдтэй албан ёсны холбоо тогтоож нөхөрсөгөөр хандсан эрдэмтэн бол Роберт А.Скалапино юм. Тэрээр 1985 оны 10-р сард долоон том мэргэжилтний хамт Улаанбаатарт ирж монголын эрдэмтэдтэй уулзаж монголын гадаад бодлого, олон улсын харилцааны асуудал болон монгол судлалын талаар илэн далангүй санал солилцжээ. Тэр үеэр Академич Н.Ишжамц, Ч.Далай нартай тусгайлан уулзан зүүн хойт азийн орнуудын хамтын ажиллагааны талаар санал солилцжээ. А.Скалапино цаашлан Орос, Монгол, Хятад, Гонконг, Тайвань, Өмнөт Солонгост очиж сурвалжлага судалгаа хийжээ. Буцаж очоод “Зүүн хойт Ази дахь их гүрнүүдийн харилцаа”¹⁸, “Зүүн хойт Ази дахь Японы үүрэг холбогдол”, “Хятад ба зүүн хойт Ази”¹⁹ зэрэг зохиол бүтээл бичиж нийтлүүлжээ.

Түүнээс хойш Роберт А.Скалапино монголын талаар олон зүйлийг санаачлан хийжээ. Америк, Улаанбаатарт Монгол-Америкийн эрдэмтэдийн хоёр талын уулзалтыг хоёр удаа зохион байгуулсан. Улаанбаатарт Зүүн хойт орнуудын улс төр, эдийн засгийн талаар симпозиум зохион байгуулж өөрөө оролцон илтгэл тавьжээ. Монголд хоёр гурван удаа ирж монголын тухай зохих мэдлэгтэй болж монголын сайхан орон болон сайхан сэтгэлт монгол хүмүүсийг дурсан өгүүлэл бичжээ. Тэрээр Азийн орнуудаар явах бүр монголыг үнэн зөвөөр ярьж сурталчилж монголд их элэгтэй эрдэмтэн юм.

Эцэст нь: Монгол Америкийн эрдэмтэдийн хамтын ажиллагааны эхлэл тавьсан эрдэмтэдийн талаар товч зүйл бичив. Цаашид үргэлжлүүлэн дэлгэрүүлж бичнэ.

ИШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Н.Ишжамц, “АНУ-аас Монголын хувьд явуулсан бодлого, Монгол-Америкийн харилцаа /1900-1987/”.
2. Ч.Далай, “Америкийн эрдэмдэнтэй хамт явж хийсэн цуврал тэмдэглэл”, “Ерөнхийлөгч Рузвельт Монголыг их дэмжсэн” Зууны мэдээ, 1999.08.04
3. Ц.Батбаяр, “АНУ-ын Азийн бодлого”, “Дорно, өрнө” сэтгүүл, 1996 оны №4
4. А.Дамдинсүрэн, “Монгол, Америкийн харилцааны тухайд”, “Хөдөлмөр” сонин 1991.07.21, №1

5. Ц.Пунцагноров, “Монгол, Америкийн харилцааны туулсан зам, хамтын ажиллагааны өнөөгийн төлөв - “Дорно-Өрнө” сэтгүүл 1994 оны №1, 1995 оны №1-2
6. Г.Төмөрчулуун, “Америкт гадаад бодлогыг хэрхэн явуулдаг тухай: төвлөрөл ба ардчилал”, Монголын “Америк: судалгаа, мэдээлэл” сэтгүүл №1, 1994
7. Ж.Бор, “АНУ-ын Ерөнхийлөгчийн эрх мэдэл”, Монголын “Америк: судалгаа, мэдээлэл” сэтгүүл №1, 1994
8. С.Ишдорж, “АНУ бүрэлдэн тогтсон түүхээс”, Монголын “Америк: судалгаа, мэдээлэл” сэтгүүл №1-2, 1994
9. М.Хурметхан, “Америкийн түүх, өнөөгийн байдлаас өгүүлэх нь”, Монголын “Америк: судалгаа, мэдээлэл” сэтгүүл №1, 1994
10. С.Жамбалдорж, “Америк тивийг монголчууд анх нээсэн”, “Ардын эрх” сонин 1992.05.09
11. Д.Цолмон, “АНУ-ын төрийн тогтолцоо”, Монголын “Америк: судалгаа, мэдээлэл” сэтгүүл №1
12. Н.Ишжамц, “АНУ-гаас Монголын хувьд явуулсан бодлого, Монгол-Америкийн харилцаа /1900-1987/, УБ, 1999, 2-3 тал
13. R.A.Rupen. “Mongols of the twentieth century, Bloomington, 1964’
14. Академич Ч.Далайн тэмдэглэлээс
15. O.Lattimore, “Nomads and Commissars, Mongolia revisited” №1, 1962
16. Дээрх зохиолын 8-р тал
17. Robert A.Scalapino, Major Powers Relations in Northeast Asia, Lanham, №1, London, 1986
18. E.J.Lincoln, Janans Economic Role in Northeast Asia, Lanham, №1, London, 1987
19. H.Harding, China and Northeast Asia, Lanham, №1, London, 1987